

Сэтгэлээ Оюуныг Судлахуй Найман Бадаг
Шүлэг Оршвой.

- 1 Эх болсон хамаг амьтныг би бээр
Энгүй хүслийн чандмань эрдэнэд санаж
Үлэмж зарлигыг гүйцэлдүүлэх үүднээс
Үргэлжид тэднийг дээдлэх болтугай.
- 2 Хаана ч, хэнтэй ч явсан би бээр
Хэзээд өөрийгээ бусдаас дорд санаж
Өр зүрх, чинь сэтгэлээсээ
Оройдоо тэднийг дээдлэх болтугай.
- 3 Би бээр үйлдэл бүрт сэрэмжлэх болтугай
Хамгийг болон өөрийгөө хөнөөгч
Хилэнцэт санаа төрөх даруйд
Би бээр түүнийг сэтгэлээсээ таягдах болтугай.
- 4 Хилэнцэт дуршил хийгээд зовлондоо
Гаслан шаналсан амьтадтай учирахад
Ховор эрдэнэ олсон мэт
Би бээр тэднийг дээдлэх болтугай.
- 5 Хэдийд ч гэсэн бусад хүмүүс атаархан
Хилс гүжрээр намайг дайран доромжловч
Ялалтыг зөвхөн тэдэнд зориулах буюу
Ялагдлыг би бээр өөртөө хүлээх болтугай.
- 6 Миний тус хүргэсэн, эсвэл
Миний итгэл хүлээлгэсэн нэгэн
Тусыг минь усаар хариулавч
Түүнийг сайн анд гэж үзэх болтугай.
- 7 Товчдоо эх минь болсон хамаг амьтныг
Би бээр шууд хийгээд шууд бусаар ачлан үйлдьеэ.
Тэдний шаналан энэлэх зовлон бүгдийг нь
Би бээр өөртөө нууцаар авах болтугай.
- 8 Ертөнцийн найман номын шавар балчигт
Ер номд суралцагсад шигдэлгүй ариун байх болтугай! Тэд!
Юмс бүхэн зэрэглээ мэт болохыг ухааран
Юунд ч эс тачаан, мунхагийн хүлээснээс алдрах болтугай ! Тэд!